МЭДЭЭ · 2021 оны 9-р сарын 28

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДТАЙ ХАМТАРСАН ЗӨВЛӨГӨӨН ХИЙЖЭЭ



Баянзүрх дүүргийн прокурорын газраас тус дүүрэг дэх Цагдаагийн газрын 1, 2, 3 дугаар хэлтсийн болон Мэргэжлийн хяналтын хэлтсийн зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудтай хамтарсан зөвлөгөөн хийжээ.

Зөвлөгөөнөөр хяналтын ажлын явцад гарч байгаа зөрчил, дутагдал, хүндрэл бэрхшээлийн талаар хэлэлцэж, тэдгээрийг шийдвэрлэх хэд хэдэн ажил, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж ажиллахаар болсон байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2667